МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

БИЗНЕСЭЭ СЭРГЭЭХЭД ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛ, ДЭМЖЛЭГ

ТОДРУУЛАХ СУДАЛГАА

#ЭдийнЗасгийнИхСэргэлт
#TheGreatReset

АГУУЛГА

ЕРӨНХИЙ ҮР ДҮН 2

Нэг. Ковидтой холбогдох засгийн газраас хэрэгжүүлсэн арга хэмжээнээс дэмжлэг авсан эсэх 4

Засгийн газраас дэмжлэг авсан байдал 4

Засгийн газрын 3 хувийн зээл 5

Цар тахлаас урьдчилан сэргийлэх дархлаажуулалт 7

Хоёр. Ковидтой холбоотойгоор үйл ажиллагаанд орж буй өөрчлөлт, одоо үйл ажиллагаа явуулж буй нөхцөл байдал, бэрхшээл 8

Үйл ажиллагаанд орж буй өөрчлөлт 8

Санхүүжилт 8

Бизнесийн үйл ажиллагаан дахь нөлөө, бэрхшээл 9

Гурав. Бизнесийн үйл ажиллагааг сэргээхэд шаардагдах дэмжлэг, хүлээлт 13

Шаардагдах дэмжлэг 13

Бизнес эрхлэгчдийн хүлээлт 17

Дөрөв. Судалгаанд оролцогчдын мэдээлэл 18

ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН БИЗНЕСИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ (ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨРЛӨӨР) 19

ЕРӨНХИЙ ҮР ДҮН

- МҮХАҮТ-аас МУ-ын ерөнхийлөгч, УИХ, Засгийн газарт танилцуулсан “Их Сэргэлт” санаачилгыг хэрэгжүүлэх хүрээнд цар тахлын улмаас бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд гарч буй өөрчлөлт, тулгарч буй хүндрэл, шаардлагатай дэмжлэгийг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг явууллаа. Судалгааг 2021 оны 8 сарын 30-наас 9 сарын 3-ны өдрүүдэд цахим хэлбэрээр явуулж, Улаанбаатар хот болон орон нутгийн нийт 1349 бизнес эрхлэгчид оролцлоо.
- Засгийн газраас цар тахлын үед бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тодруулахад судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 61% нь ус цахилгаан, дулааны төлбөр хөнгөлөх, чөлөөлөх дэмжлэг авсан, 44% нь НДШ-ийн хөнгөлөлтөд, 17% нь 3 хувийн зээлд хамрагдсан. Харин 24% нь ямар нэг дэмжлэг аваагүй байна. Судалгаанд оролцсон 3 хувийн зээлийн хүсэлт гаргасан бизнес эрхлэгчдийн 58% нь энэ зээл нь бизнест тодорхой хэмжээнд дэмжлэг болсон гэжээ.
- Цаашид эдийн засгийг сэргээхэд хөнгөлөлттэй зээл олгохдоо зээлийн нөхцөл шаардлагыг сулруулах (64%), барьцаа хөрөнгийн шаардлагад дэмжлэг үзүүлэх (55%), зээлийн хугацааг нэмэгдүүлэх (50%) зэргийг анхаарах хэрэгтэй байна. Эцсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжүүдийн хувьд барьцаа хөрөнгийн дэмжлэг, завсрын түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдэд зээлийн хугацааг уртасгах, тээвэр зуучийн компаниудад зээлийн санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх нь хамгийн чухал байна.
- Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 83% нь цар тахлаас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээ нь хөл хорио тогтоохгүй байж, бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэхэд нөлөөлж байна гэжээ.
- Бизнес эрхлэгчид үйл ажиллагааг тасралтгүй явуулах зорилгоор дижитал шилжилттэй холбогдох техник технологийн өөрчлөлт (52%) хийх, хүргэлтийн болон цахим үйлчилгээ нэвтрүүлэх, төлбөрийн илүү уян хатан нөхцөл санал болгох, харилцагчдад үйлчлэх үйлчилгээг илүү идэвхжүүлэх зэрэг үйлчлүүлэгчид чиглэсэн өөрчлөлт, шинэчлэлт хийсэн байна.
- Ковидээс сэргийлэх, хөл хорионы хязгаарлах арга хэмжээ нь бараа, үйлчилгээний эрэлт буурах (51%), эргэлтийн хөрөнгийн хомстолд орсон (51%), тээвэр логистик доголдсоноос бараа, үйлчилгээг хугацаанд нь нийлүүлж чадахгүй (43%) байгаа зэргээр бизнест голлон нөлөөлж байна. Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, үйлчилгээний бизнес эрхлэгчид эргэлтийн хөрөнгийн хомстолд орсон байгаа бол завсрын түүхий эд бэлтгэн нийлүүлэгчид, тээвэр зууч эрхлэгчдийн хувьд тээвэр логистик доголдсоноор бараа, үйлчилгээг хугацаанд нь нийлүүлж чадахгүй байна.
- Бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулахад тулгарч буй хамгийн хүндрэлтэй саад бэрхшээлийг эрэмбэлэхэд (1) бэлэн мөнгөний (эргэлтийн хөрөнгийн) хомстол (2) бизнес эрхлэх тодорхойгүй нөхцөл байдал, (3) тээвэр ложистиктой холбогдох удаашрал, тасалдал гэсэн 3 асуудал хамгийн хүндрэлтэй байна. Орон нутгийн бизнес эрхлэгчдийн хувьд бизнес эрхлэх тодорхойгүй нөхцөл байдал хүндрэл үүсгэж байна.
- Цаашид бизнесийн үйл ажиллагааг хэвийн явуулах болон сэргээхэд нийт судалгаанд оролцогчдын 36% нь засгийн газрын 3 хувийн зээл, 27% нь банкны бизнесийн зээл, 28% нь өөрийн эргэлтийн хөрөнгөөр санхүүжүүлж (төлөвлөж) байгаа бол, 29% нь ямар нэг эх үүсвэр байхгүй байна. Эцсийн болон завсрын бүтээгдэхүүн, түүхий эд үйлдвэрлэгчид засгийн газрын 3 хувийн зээл болон банкны бизнесийн зээлээр санхүүжүүлж (төлөвлөж) байна.

- Бизнесээ сэргээхэд шаардагдах дэмжлэгээр санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлттэй зээл олгох (53%), ААН-ийн албан татварыг хойшлуулах хөнгөлөх (43%), бизнесийн үйл ажиллагааг сэргээхэд төрийн нэгдсэн зохицуулалт хийх, төрийн үйлчилгээний хүнд суртлыг бууруулах чиглэлд анхааран ажиллах (37%) зэргийг нэрлэжээ. Мөн эцсийн болон завсрын бүтээгдэхүүн, түүхий эд үйлдвэрлэгч, үйлчилгээ үзүүлэгч бизнес эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг, тээвэр зуучийн аж ахуйн нэгжүүдэд тээвэр ложистикийн нөхцөлийг сайжруулах, бизнесийн үйл ажиллагааг сэргээж, хэвийн явуулахад төрийн нэгдсэн зохицуулалт хийж, төрийн үйлчилгээний хүнд суртлыг бууруулан ажиллах хэрэгтэй байна.
- Судалгаанд оролцогсдын 60 орчим хувь нь байгууллагаас болон ажилтнаас суутгадаг НДШ-ээс чөлөөлөх, НӨАТ-ыг ижил суурьтай болгох (36%) нь бизнесээ сэргээхэд бодит дэмжлэг болно гэжээ. Түүнчлэн ковидийн үед үйлдвэр шинээр барих, өргөтгөх болон том төслүүдийн бүтээн багуулалттай холбогдох тоног төхөөрөмжид татварын хөнгөлөлт үзүүлэх, уурхайн бус үндэсний үйлдвэрлэгч, жижиг дунд үйлдвэрийг дэмжсэн татварын бодлого шаардлагатай байна гэсэн байна.
- Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 60% нь манай улсын эдийн засаг нэг жилээс дээш хугацааны дараа хэвийн түвшинд орно гэж таамаглаж байна. Харин бизнес эрхлэгчдийн 21% нь ирэх 6-12 сарын хугацаанд, 42% нь нэгээс дээш жилийн дараа бизнесийн орлого эргээд хэвийн түвшиндээ очно гэсэн хүлээлттэй байна.

Нэг. Ковидтой холбогдох засгийн газраас хэрэгжүүлсэн арга хэмжээнээс дэмжлэг авсан эсэх

Засгийн газраас дэмжлэг авсан байдал

Засгийн газраас цар тахлын үед бизнес, эдийн засгийг дэмжих чиглэлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнээс бизнес эрхлэгчид хэрхэн дэмжлэг авсан тухайд тодруулахад судалгаанд оролцогчдын 61% нь ус цахилгаан, дулааны төлбөр хөнгөлөх, чөлөөлөх, 44% нь НДШ-ийн хөнгөлөлтөд хамрагдсан бол 17% нь 3 хувийн зээлд хамрагдсан байна. Харин 24% нь ямар нэг дэмжлэг аваагүй байна. (Зураг 1)

Судалгаанд оролцсон орон нутгийн бизнес эрхлэгчдийн 70% нь ус, цахилгаан, дулааны төлбөр хөнгөлөх чөлөөлөх арга хэмжээнд, 44% нь НДШ-ийн хөнгөлөлтөд хамрагдсан бол 29% нь засгийн газрын 3 хувийн зээл авчээ.

Зураг 1. Цар тахлын үед засгийн газрын дэмжлэг авсан байдал

Аж ахуйн нэгжийн төрөл харгалзахгүйгээр судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн хамгийн өндөр хувьтай дэмжлэг хүртсэн арга хэмжээ нь ус цахилгаан, дулааны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх арга хэмжээ байна. 3 хувийн зээлд эцсийн болон завсрын бүтээгдэхүүн, түүхий эд үйлдвэрлэгчид хамрагдсан бол тээвэр зууч, үйлчилгээний бизнес эрхлэгчдийн хувьд ямар нэгэн дэмжлэг аваагүй гэсэн хариулт нь бусад төрлийн бизнес эрхлэгчдээс өндөр хувьтай байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Засгийн газрын дэмжлэг авсан байдал, бизнесийн төрлөөр

Дэмжлэг, үйл ажиллагааны нэр төрөл	Эцсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч	Завсрын түүхий эд бэлтгэн нийлүүлэгч	Тээвэр, зууч	Бусад төрлийн үйлчилгээ үзүүлэгч
Ус цахилгаан дулааны төлбөр хөнгөлөх чөлөөлөх арга хэмжээнд хамрагдсан	70%	55%	55%	58%
НДШ-ийн хөнгөлөлтөд хамрагдсан	49%	45%	48%	41%
Ямар нэг дэмжлэг аваагүй	19%	16%	24%	28%
Засгийн газрын 3 хувийн зээлд хамрагдсан	23%	20%	19%	14%
Татвар ногдох орлогын нийт дүн нь өмнөх татварын жилд 1.5 тэрбум төгрөгөөс бага орлоготой ААН орлогын албан татвараас чөлөөлөгдсөн	15%	13%	15%	12%
Татвартай холбогдох торгууль, алдангиас чөлөөлөгдсөн	5%	8%	10%	5%
Зарим хүнсний гол нэрийн барааг гаалийн албан татвар, НӨАТ-аас чөлөөлсөн (улаан буудай, хүнсний будаа, элсэн чихэр, ургамлын тос г.м)	2%	6%	3%	3%

Засгийн газрын 3 хувийн зээл

Судалгаанд оролцсон нийт бизнес эрхлэгчдийн 49% нь 3 хувийн зээлд хүсэлт гаргасан бол 43% нь хүсэлт гаргаагүй, 8% нь зээл авахаар бэлтгэж байна. Судалгаанд оролцсон, зээлийн хүсэлт гаргасан бизнес эрхлэгчдээс энэхүү зээл бодит дэмжлэг болсон эсэхийг тодруулахад 39% нь тодорхой хэмжээнд дэмжлэг болсон, 19% нь маш сайн дэмжлэг болсон гэсэн бол 28% нь дэмжлэг болоогүй, 13% мэдэхгүй гэж хариулжээ. (Зураг 2).

Зураг 2. Засгийн газрын 3 хувийн зээлд хүсэлт гаргасан, зээл нь дэмжлэг болсон эсэх



Цаашид эдийн засгийг сэргээх, тодорхой салбарыг дэмжсэн зээлийн хөтөлбөр ба хөнгөлөлттэй зээл хэрэгжүүлбэл анхаарах асуудлуудын тухайд бизнес эрхлэгчдийн 64% нь зээлийн нөхцөл шаардлагыг сулруулах, 55% нь барьцаа хөрөнгийн шаардлагад дэмжлэг үзүүлэх, 50% нь зээлийн хугацааг уртасгах, 43% нь зээлийн санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна гэжээ. (Зураг 3)

Зураг 3. Хөнгөлөлттэй зээл олгоход анхаарах асуудлууд



Харин орон нутгийн бизнес эрхлэгчдийн хувьд зээлийн нөхцөл, шаардлагыг сулруулах (59%), зээлийн хугацааг нэмэгдүүлэх (55%), барьцаа хөрөнгийн шаардлага (49%) дээр дэмжлэг үзүүлэх нь чухал гэж үзжээ.

Нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч аж ахуйн нэгжийн төрлөөр цаашид хөнгөлөлттэй зээл олгоход анхаарах асуудлуудыг нарийвчлан авч үзвэл эцсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, бүх төрлийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжүүдийн хувьд барьцаа хөрөнгийн дэмжлэг, зээлийн нөхцөл шаардлагыг сулруулах тал дээр анхаарах шаардлагатай гэсэн бол завсрын түүхий эд бэлтгэгч аж ахуйн нэгжүүдэд зээлийн хугацааг уртасгах, зээлийн нөхцөлийн сулруулах хэрэгтэй гэжээ. Харин тээвэр зуучийн компаниудын хувьд зээлийн санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлж, хугацааг уртасгах, мөн барьцаа хөрөнгийн шаардлагад дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Хөнгөлөлттэй зээл олгоход анхаарах асуудлууд, бизнесийн төрлөөр

Анхаарах асуудлууд	Эцсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч	Завсрын түүхий эд бэлтгэн нийлүүлэгч	Тээвэр, зуучь	Бусад төрлийн үйлчилгээ үзүүлэгч
Зээлийн нөхцөл, шаардлагыг сулруулах	**62%**	**57%**	52%	**66%**
Барьцаа хөрөнгийн дэмжлэг	**53%**	51%	**58%**	**55%**
Зээлийн хугацааг нэмэгдүүлэх	52%	**53%**	**54%**	48%
Зээлийн санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх	43%	38%	**54%**	42%
Зээлийн мэдээллийг түгээх	18%	26%	22%	20%

Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулж байгаа салбараар нь авч үзвэл бүх салбаруудад зээлийн нөхцөл, шаардлагыг сулруулах хэрэгтэй байна. Гадаад худалдаа, хүнсний боловсруулах үйлдвэрлэл, мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарт барьцаа хөрөнгийн дэмжлэг хэрэгтэй байна. Хөдөө аж ахуй, дотоодын тээврийн бизнес эрхлэгчдэд зээлийн хугацааг уртасгах, олон улсын тээврийн компаниудад зээлийн хэмжээг нэмэгдүүлэх нь чухал байна. (Зураг 4).

Зураг 4. Хөнгөлөлттэй зээл олгоход анхаарах асуудлууд, салбараар



Тайлбар: дундаж үнэлгээгээр хамгийн их анхаарах асуудлаар эрэмбэлэв

Цар тахлаас урьдчилан сэргийлэх дархлаажуулалт

2021 оны 9 сарын байдлаар Монгол улс цар тахлаас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын бүрэн тунд хүн амын 60% орчим нь хамрагдаад байгаа. Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 83% нь энэхүү дархлаажуулалтын арга хэмжээ нь хөл хорио тогтоохгүй байж, бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэхэд нөлөөтэй байсан гэж хариулжээ. (Зураг 5)

Зураг 5. Цар тахлаас урьдчилан сэргийлэх дархлаажуулалт бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад нөлөөлсөн эсэх



Хоёр. Ковидтой холбоотойгоор үйл ажиллагаанд орж буй өөрчлөлт, одоо үйл ажиллагаа явуулж буй нөхцөл байдал, бэрхшээл

Бизнесийн байгууллагууд, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн үйл ажиллагаанд цар тахал их, бага хэмжээгээр нөлөөлж, бизнес эрхлэгчид ковидийн тодорхойгүй нөхцөлд зохицон үйл ажиллагаа явуулах олон сорилтуудтай тулгарч байгаа билээ. Судалгааны энэ хэсэгт ковидийн үед бизнесийн үйл ажиллагаа хэрхэн өөрчлөгдөж байгаа, үйл ажиллагаагаа хэвийн явуулахад тулгарч буй саад, бэрхшээлийг тодруулахыг зорьсон болно.

Үйл ажиллагаанд орж буй өөрчлөлт

Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдээс ковидийн үед бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахын тулд шинэ зүйл нэвтрүүлэн техник технологийн ямар нэг шинэчлэлт хийсэн талаар тодруулахад 39% нь шинэчлэлт хийсэн бол 61% нь өөрчлөлтгүй байна.

Бизнесийн тасралтгүй байдлыг хангахын тулд шинэчлэлт хийсэн бизнес эрхлэгчдээс үйл ажиллагаандаа ямар шинэ зүйл нэвтрүүлэн ажиллаж байгаа тухайд тодруулахад 52% нь дижитал шилжилттэй холбогдох техник технологийн өөрчлөлт хийжээ. Харин 40 орчим хувь нь хүргэлтийн болон цахим үйлчилгээ нэвтрүүлэх, төлбөрийн илүү уян хатан нөхцөл санал болгох, харилцагчдад үйлчлэх үйлчилгээг илүү идэвхжүүлэх зэрэг харилцагч, үйлчлүүлэгчид чиглэсэн өөрчлөлт, шинэчлэлт хийсэн байна. (Зураг 6)

Зураг 6. Бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Санхүүжилт

Цаашид бизнесийн үйл ажиллагааг хэвийн явуулах болон сэргээхэд ямар эх үүсвэрээр санхүүжүүлэх төлөвлөгөөтэй байгаа тухайд нийт судалгаанд оролцогчдын 36% нь засгийн газрын 3 хувийн зээл, 27% нь банкны бизнесийн зээл гэсэн бол 28% нь өөрийн эргэлтийн хөрөнгөөр санхүүжүүлнэ гэжээ. Харин 29% нь ямар нэг эх үүсвэр байхгүй гэж хариулсан байна. (Зураг 7)

Зураг 7. Бизнесээ сэргээхэд санхүүжүүлэх эх үүсвэр



Бизнесийн үйл ажиллагаагаа явуулах эсвэл сэргээхэд шаардагдах санхүүжилтийг ямар эх үүсвэрээр шийдэж байгааг бизнесийн үйл ажиллагааны төрлөөр нарийвчлан харвал эцсийн болон завсрын бүтээгдэхүүн, түүхий эд үйлдвэрлэгчид засгийн газрын 3 хувийн зээл болон банкны бизнесийн зээлээр санхүүжүүлж байгаа болон цаашид энэ төрлийн зээл авах төлөвлөгөөтэй байна. Харин тээвэр зуучийн бизнес эрхлэгчид өөрийн эргэлтийн хөрөнгө болон банкны бизнесийн зээлээр санхүүжүүлэх, үйлчилгээ үзүүлэгч бизнес эрхлэгчид өөрийн эргэлтийн хөрөнгөөр санхүүжүүлэх эсвэл одоогоор төлөвлөсөн эх үүсвэр байхгүй байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Бизнесээ сэргээх, үйл ажиллагаа явуулахад санхүүжүүлэх эх үүсвэр, бизнесийн төрлөөр

Санхүүгийн эх үүсвэр	Эцсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч	Завсрын түүхий эд бэлтгэн нийлүүлэгч	Тээвэр, зууч	Бусад төрлийн үйлчилгээ үзүүлэгч
Өөрийн эргэлтийн хөрөнгө, хадгаламж	26%	26%	31%	29%
Банкны бизнесийн зээл	26%	30%	37%	27%
ЗГ-ын 3 хувийн зээл	43%	47%	30%	31%
Ямар нэг эх үүсвэр байхгүй	24%	25%	28%	31%

Бизнесийн үйл ажиллагаан дахь нөлөө, бэрхшээл

Цар тахлаас сэргийлэх, хөл хорионы хязгаарлах арга хэмжээ нь бизнесийн үйл ажиллагаанд ямар нөлөөтэй байгааг тодруулахад судалгаанд оролцогсдын 51% нь бараа, үйлчилгээний эрэлт буурсан, 51% нь эргэлтийн хөрөнгийн хомстолд орсон, 43% нь тээвэр логистик доголдсоноос бараа, үйлчилгээг хугацаанд нь нийлүүлж чадахгүй байна. (Зураг 8)

Орон нутгийн бизнес эрхлэгчдийн хувьд мөн адил бараа, үйлчилгээний эрэлт буурсан (52%), бэлэн мөнгөний хомстолд орсон (41%), түүхий эдийн нийлүүлэлт доголдсоноос үйлдвэрлэл тасалдсан (34%) байна.

Зураг 8. Цар тахлын бизнесийн үйл ажиллагаан дахь нөлөө

Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны төрөл харгалзахгүйгээр бараа үйлчилгээний эрэлт буурсан нь бизнесийн үйл ажиллагаанд голлон нөлөөлж байна. Түүнчлэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, үйлчилгээний бизнес эрхлэгчид эргэлтийн хөрөнгийн хомстолд орсон бол завсрын түүхий эд бэлтгэн нийлүүлэгчид, тээвэр зууч эрхлэгчдийн хувьд тээвэр логистик доголдсоноор бараа, үйлчилгээг хугацаанд нь нийлүүлж чадахгүй байна. (Хүснэгт 4)

Хүснэгт 4. Бизнесийн үйл ажиллагаан дахь нөлөө, бизнесийн төрлөөр

Бизнес дэх нөлөө	Эцсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч	Завсрын түүхий эд бэлтгэн нийлүүлэгч	Тээвэр зууч	Бусад төрлийн үйлчилгээ үзүүлэгч
Бараа/үйлчилгээний эрэлт буурсан	55%	43%	43%	50%
Бэлэн мөнгөний (эргэлтийн хөрөнгийн) хомстолд орсон	50%	38%	40%	53%
Тээвэр, логистикт доголдсоноос бараа/үйлчилгээг хугацаанд нь нийлүүлж чадахгүй болсон	39%	47%	72%	42%
Бизнес, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад тодорхойгүй байдал үүссэн ба шийдвэр гаргах боломжгүй болсон	29%	34%	34%	34%
Түүхий эдийн нийлүүлэлт доголдсоноос үйлдвэрлэл тасалдсан	48%	40%	13%	14%
Ажилтнуудыг түр болон бүрмөсөн чөлөөлсөн	20%	19%	15%	24%
Хүний нөөцийн хомстолд орсон	23%	21%	15%	20%
Хүний нөөцтэй холбогдох зардал өссөн (хамгаалах хэрэгслээр хангах г.м)	19%	25%	16%	20%
Бараа/үйлчилгээний эрэлт нэмэгдсэн	6%	7%	18%	7%

Бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулахад хамгийн хүндрэлтэй саад бэрхшээлийг эрэмбэлэхэд (1) бэлэн мөнгөний (эргэлтийн хөрөнгийн) хомстол (2) бизнес эрхлэх тодорхойгүй нөхцөл байдал, (3) тээвэр ложистиктой холбогдох удаашрал, тасалдал гэсэн асуудлуудыг нэрлэсэн байна. (Зураг 9).

Мөн бизнесээ хэвийн явуулах, сэргээхэд тулгарч буй бэрхшээлийн талаар нээлттэй асуулгаар асуухад түүхий эдийн үнийн өсөлт, төрийн байгууллагаас олгодог тусгай зөвшөөрөл лицензавах үйл явц, хуримтлагдсан татвар, НДШ-ийн өр хүндрэл үүсгэж байна.

Зураг 9. Бизнесийн үйл ажиллагаа тасралтгүй явуулахад тулгарч буй саад, бэрхшээл



Орон нутгийн бизнес эрхлэгчдийн хувьд бизнес эрхлэх тодорхойгүй нөхцөл байдал, түүхий эдийн нийлүүлэлт алдагдах хомстох, мөн тээвэр, ложистиктой холбогдох удаашрал, тасалдал хүндрэл үүсгэж байна.

Бизнесээ сэргээх, тасралтгүй үйл ажиллагаа явуулахад тулгарч буй бэрхшээлийг салбараар авч үзвэл бүх салбарт эргэлтийн хөрөнгийн хомстол, бизнесийн тодорхойгүй нөхцөл байдал хүндрэлтэй байна. Мөн олон улсын болон дотоодын тээвэр, уул уурхай, гадаад худалдааны бизнес эрхлэгчдэд тээвэр, ложистиктой холбогдох удаашрал тасалдал бэрхшээл үүсгэж байгаа бол боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбарт түүхий эдийн хомстол хүндрэл үүсгэж байна. (Зураг 10)

Зураг 10. Бизнесийн үйл ажиллагаа тасралтгүй явуулахад тулгарч буй саад, бэрхшээл, салбараар



Тайлбар: дундаж үнэлгээгээр хамгийн их тулгарч буй саад бэрхшээлээр эрэмбэлэв

Гурав. Бизнесийн үйл ажиллагааг сэргээхэд шаардагдах дэмжлэг, хүлээлт

Шаардагдах дэмжлэг

Бизнесээ сэргээж, үйл ажиллагаагаа хэвийн явуулахад төрөөс ямар дэмжлэг шаардлагатай байгаа тухайд нийт судалгаанд оролцогчдын 53% нь санхүүгийн дэмжлэг, 43% нь ААН-ийн албан татварыг хойшлуулах, хөнгөлөх, 37% нь бизнесээ сэргээхэд төрийн нэгдсэн зохицуулалт хийх, төрийн үйлчилгээний хүнд суртлыг бууруулах чиглэлд анхааран ажиллах шаардлагатай байна гэжээ. (Зураг 11)

Зураг 11. Бизнесээ сэргээхэд шаардагдах дэмжлэг, арга хэмжээ



Орон нутгийн бизнес эрхлэгчдийн хувьд ААН-ийн албан татварыг хойшлуулах хөнгөлөх (51%), санхүүгийн дэмжлэг үзүүлэх (47%), хориг цуцалсны дараа бизнесийг сэргээж хэвийн явуулахад нэгдсэн зохицуулалт хийх (33%) арга хэмжээнүүдийг онцолжээ.

Бизнесийн үйл ажиллагааг сэргээн, хэвийн явуулахад бүх төрлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд албан татварыг хөнгөлөх, хойшлуулах нь дэмжлэг болно гэжээ. Түүнчлэн эцсийн болон завсрын бүтээгдэхүүн, түүхий эд үйлдвэрлэгч, үйлчилгээ үзүүлэгч бизнес эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлттэй зээл хамгийн чухал шаардлагатай байна. Харин тээвэр зуучийн аж ахуйн нэгжүүдэд тээвэр ложистикийн нөхцөлийг сайжруулах, бизнесийн үйл ажиллагааг сэргээж, хэвийн явуулахад төрийн нэгдсэн зохицуулалт хийж, төрийн үйлчилгээний хүнд суртлыг бууруулах чиглэлд анхаарч ажиллах хэрэгтэй байна. (Хүснэгт 5)

Хүснэгт 5. Бизнесээ сэргээхэд шаардагдах дэмжлэг, арга хэмжээ, бизнесийн төрлөөр

Бизнесээ сэргээхэд шаардагдах дэмжлэг	Эцсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч	Завсрын түүхий эд бэлтгэн нийлүүлэгч	Тээвэр, зууч	Бусад төрлийн үйлчилгээ үзүүлэгч
Санхүүгийн дэмжлэг (хөнгөлөлттэй зээл, барьцаагүй, урт хугацаат санхүүжилт)	62%	43%	36%	51%
ААН-ийн албан татварыг хойшлуулах, хөнгөлөх	39%	51%	42%	45%
Хориг цуцалсны дараа бизнесийг сэргээж хэвийн явуулахад нэгдсэн зохицуулалт хийх (Төрийн байгууллагын үйлчилгээний хүнд суртлыг бууруулах гм)	33%	34%	49%	38%
Нөхцөл байдал хүнд болсон ч бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах (хөл хорионд оруулахгүй байх)	32%	22%	24%	32%
Тээвэр, ложистикийн нөхцөлийг сайжруулах	28%	29%	55%	27%
Ач холбогдол, үр нөлөө багатай шаардлага, үнэлгээ, зөвшөөрлийн тоог багасгах, хялбаршуулах	23%	24%	30%	29%
Бизнесийн үйл ажиллагааны зардлыг бууруулахад чиглэсэн дэмжлэг (түрээс бууруулах г.м)	25%	17%	22%	27%
Бараа бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих чиглэлд илүү үр дүнтэй бодлого хэрэгжүүлэх	34%	27%	16%	14%
Цаашид үйл ажиллагааг хязгаарлах салбарын тухай тодорхой мэдээллээр хангах	12%	16%	15%	20%
Вирусийн нөхцөл байдлыг хянах арга хэрэгслийг нэвтрүүлэх, ингэснээр бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах боломжийг бүрдүүлнэ	12%	19%	16%	16%
Төрийн худалдан авалтад дотоодын бараа, үйлчилгээг авч дэмжих	24%	18%	10%	9%
Шаардлага хангахуйц мэргэжлийн ажиллах хүчний олдцыг нэмэгдүүлэх	12%	11%	10%	10%

Шаардлагатай дэмжлэгийг салбараар нь нарийвчлан харвал бүх салбаруудад санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлттэй зээл хэрэгтэй байна. Мөн олон улсын болон дотоодын тээвэр, уул уурхайн бизнес эрхлэгчдэд тээвэр ложистикийн нөхцөлийг сайжруулах, мэдээлэл технологи, барилга, аялал жуулчлалын салбарт аж ахуйн нэгжийн албан татварыг хойшлуулах хөнгөлөх дэмжлэг чухал байна гэжээ. (Зураг 12)

Зураг 12. Бизнесээ сэргээхэд шаардагдах дэмжлэг, арга хэмжээ,салбараар



Тайлбар: дундаж үнэлгээгээр хамгийн их шаардагдах дэмжлэгээр эрэмбэлэв

МҮХАҮТ-аас хийсэн Ковидийн үеийн бизнесийн нөхцөл байдлын судалгаануудад бизнес эрхлэгчдэд төрөөс татварын хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх нь илүү бодит дэмжлэг болдог тухай дурдсан байдаг. Иймд бизнесээ сэргээхэд төрөөс ямар төрлийн татварын дэмжлэг үзүүлэх нь үр дүнтэй байх тухай тодруулахад судалгаанд оролцогсдын 64% нь байгууллагаас хариуцдаг НДШ-ээс чөлөөлөх, 58% нь ажилтнаас суутгадаг НДШ, ХХОАТ-аас чөлөөлөх, 36% нь НӨАТ-ыг ижил суурьтай болгох нь бодит дэмжлэг болно гэжээ. Түүнчлэн ковидийн үед үйлдвэр шинээр барих, өргөтгөх болон том төслүүдийн бүтээн байгуулалттай холбогдох тоног төхөөрөмжид татварын хөнгөлөлт үзүүлэх, уул уурхайн бус үндэсний үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэрийг дэмжсэн татварын бодлого шаардлагатай гэсэн байна. (Хүснэгт 6)

Хүснэгт 6. Дэмжлэг шаардлагатай байгаа татварын нэр төрөл

Хариултын хувь	Татварын нэр төрөл
64%	НДШ-ээс чөлөөлөх- байгууллагаас хариуцах
58%	НДШ, ХХОАТ-аас чөлөөлөх- ажилтнаас суутгах
36%	НӨАТ-ыг ижил суурьтай болгох
34%	Үйлдвэр шинээр барих, үйлдвэрийг өргөтгөхөд тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг импортын болон гаалийн татвараас чөлөөлөх
31%	Том төслүүд болон үйлдвэрүүд өндөр өртөгтэй дэвшилтэт тоног төхөөрөмж машин техник оруулж ирэн үйл ажиллагаандаа ашиглахад НӨАТ, гаалийн татвараас чөлөөлөх, татварыг хойшлуулах, хэсэгчлэн төлөх боломж бий болгох
24%	Газар, үл хөдлөх хөрөнгийн татвараас чөлөөлөх

Бизнесийн үйл ажиллагааг хэвийн явуулах, сэргээхэд үйл ажиллагааны төрөл харгалзахгүйгээр байгууллагаас хариуцдаг НДШ, ажилтнаас суутгадаг НДШ, ХХОАТ-г чөлөөлөх, хөнгөлөх нь бодит дэмжлэг болдог байна. Мөн эцсийн болон завсрын бүтээгдэхүүн, түүхий эд үйлдвэрлэгчдийн хувьд шинэ үйлдвэр барих, өргөтгөхтэй холбогдох тоног төхөөрөмжид татварын хөнгөлөлт үзүүлэх нь дэмжлэг болно гэсэн бол тээвэр зууч, үйлчилгээний бизнес эрхлэгчдийн хувьд НӨАТ-ыг ижил суурьтай болгох нь бизнес дэмжлэг болно гэжээ. (Хүснэгт 7)

Хүснэгт 7. Дэмжлэг шаардлагатай байгаа татварын нэр төрөл, бизнесийн төрлөөр

Татварын дэмжлэг	Эцсийн шатны бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч	Завсрын шатны түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч	Тээвэр, зууч	Бусад төрлийн үйлчилгээ үзүүлэгч
НДШ-ээс чөлөөлөх- байгууллагаас хариуцах	63%	61%	55%	66%
НДШ, ХХОАТ-аас чөлөөлөх- ажилтнаас суутгах	54%	58%	52%	60%
НӨАТ-ыг ижил суурьтай болгох	38%	25%	39%	36%
Үйлдвэр шинээр барих, үйлдвэрийг өргөтгөхөд тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг импортын болон гаалийн татвараас чөлөөлөх	45%	47%	28%	27%
Том төслүүд болон үйлдвэрүүд өндөр өртөгтэй дэвшилтэт тоног төхөөрөмж машин техник оруулж ирэн үйл ажиллагаандаа ашиглахад НӨАТ, гаалийн татвараас чөлөөлөх, татварыг хойшлуулах, хэсэгчлэн төлөх боломж бий болгох	34%	39%	33%	29%
Газар, үл хөдлөх хөрөнгийн татвараас чөлөөлөх	22%	28%	19%	25%

Бизнес эрхлэгчдийн хүлээлт

Эдийн засаг, бизнес дэх цар тахлын нөлөө ямар хугацааны дараа арилж эргээд хэвийн түвшинд орох тухайд бизнес эрхлэгчдийн хүлээлтийг тодрууллаа. Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 60% нь манай улсын эдийн засаг нэг жилээс дээш хугацааны дараа хэвийн түвшинд орно гэж таамаглаж байна. Харин тухайн бизнесийн орлого цар тахлын өмнөх хэвийн түвшинд очих тухайд 21% нь ирэх 6-12 сарын хугацаанд, 42% нь нэгээс дээш жилийн дараа эргээд хэвийн түвшиндээ очно гэсэн хүлээлттэй байна. (Зураг 13).

Зураг 13. Эдийн засаг, бизнесийн талаар бизнес эрхлэгчдийн хүлээлт

Дөрөв. Судалгаанд оролцогчдын мэдээлэл

Судалгааг Улаанбаатар хот, орон нутгийн бизнес эрхлэгчдийн дунд цахим хэлбэрээр 2021 оны 8 сарын 30-наас 9 сарын 3-ний өдрүүдэд явуулсан бөгөөд МҮХАҮТ-ын гишүүн болон гишүүн бус 1349 аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг хамруулав.

Нийт судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагаа явуулж буй байршлаар нь ангилан харвал 89% нь Улаанбаатар, 11% нь орон нутагт байна. Салбараар нь авч үзвэл 23% нь үйлчилгээ, 20% нь дотоод худалдаа, 12% гадаад худалдаа, 8% нь хүнсний бус үйлдвэр, 8% нь хүнсний үйлдвэр байна. Ажиллагсдын тоогоор нь авч үзвэл 53% нь 19 хүртэлх ажилтантай, 21% нь 20-199 хүртэлх ажилтантай, 4% нь 200- аас дээш ажилтантай байгаа бол 22% нь хувиараа бизнес эрхлэгч байна. Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 49% нь 100 саяас доош орлоготой бизнес эрхлэгчид, 35% нь 101-1 тэрбум төгрөгийн орлоготой, 16% нь нэг тэрбумаас дээш орлоготой аж ахуйн нэгжүүд байна.





ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН БИЗНЕСИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ (ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨРЛӨӨР)

	Түүхий эд бэлтгэн, нийлүүлэгч	Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч	Тээвэр зуучлах	Үйлчилгээ
ДЭМЖЛЭГ АВСАН ЭСЭХ	1. Ус цахилгаан дулааны төлбөр хөнгөлөлт, чөлөөлөлт (55%) 2. НДШ-ийн хөнгөлөлөлт(45%) 3. ЗГ-ын 3 хувийн зээл (20%) 4. Дэмжлэг аваагүй (16%)	1. Ус цахилгаан дулааны төлбөр хөнгөлөлт, чөлөөлөлт (70%) 2. НДШ-ийн хөнгөлөлөлт (49%) 3. ЗГ-ын 3 хувийн зээл (23%) 4. Дэмжлэг аваагүй (19%)	1. Ус цахилгаан дулааны төлбөр хөнгөлөлт, чөлөөлөлт (55%) 2. НДШ-ийн хөнгөлөлөлт (48%) 3. ЗГ-ын 3 хувийн зээл (19%) 4. Дэмжлэг аваагүй (24%)	1. Ус цахилгаан дулааны төлбөр хөнгөлөлт, чөлөөлөлт (58%) 2. НДШ-ийн хөнгөлөлөлт (41%) 3. ЗГ-ын 3 хувийн зээл (14%) 4. Дэмжлэг аваагүй (28%)
САД, БЭРХШЭЭЛ	1. Тээвэр, ложистиктой холбогдох удаашрал, тасалдал (47%) 2. Эргэлтийн хөрөнгийн хомстол (38%) 3. Түүхий эдийн нийлүүлэлт алдагдах, хомстох (37%)	1. Эргэлтийн хөрөнгийн хомстол (51%) 2. Түүхий эдийн нийлүүлэлт алдагдах, хомстох (51%) 3. Тээвэр, ложистиктой холбогдох удаашрал, тасалдал (41%)	1. Тээвэр, ложистиктой холбогдох удаашрал, тасалдал (75%) 2. Эргэлтийн хөрөнгийн хомстол (40%) 3. Хэрэглэгчийн захиалгыг түргэн шуурхай хүргэх (36%)	1. Эргэлтийн хөрөнгийн хомстол (53%) 2. Тээвэр, ложистиктой холбогдох удаашрал, тасалдал (41%) 3. Хамтран ажилладаг компаниуд, түүхий эд, бараа материал нийлүүлэгчид үйл ажиллагаагаа сэргээн, тасралтгүй явуулах (29%)
ЦААШИД ШААРДАГДАХ ДЭМЖЛЭГ	1. ААН-ийн албан татварыг хойшлуулах, хөнгөлөх (51%) 2. Санхүүгийн дэмжлэг (43%) 3. Бизнес сэргээх нэгдсэн зохицуулалт хийх, төрийн үйлчилгээний хүнд суртлын бууруулах (34%)	1. Санхүүгийн дэмжлэг (62%) 2. ААН-ийн албан татварыг хойшлуулах, хөнгөлөх (39%) 3. Бизнес сэргээх нэгдсэн зохицуулалт хийх, төрийн үйлчилгээний хүнд суртлын бууруулах (33%)	1. Тээвэр, ложистикийн нөхцөлийг сайжруулах (55%) 2. Бизнес сэргээх нэгдсэн зохицуулалт хийх, төрийн үйлчилгээний хүнд суртлын бууруулах (42%) 3. ААН-ийн албан татварыг хойшлуулах, хөнгөлөх (42%)	1. Санхүүгийн дэмжлэг (51%) 2. ААН-ийн албан татварыг хойшлуулах, хөнгөлөх (45%) 3. Бизнес сэргээх нэгдсэн зохицуулалт хийх, төрийн үйлчилгээний хүнд суртлын бууруулах (38%)